Source: www.resourcecontracts.mn

ӨМНӨГОВЬ АЙМАГ

TERRA ENERGY

НОЁН СУМ

# ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

2017 оны 09 сарын 11-ны өдөр

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

**БАТЛАВ:**

| ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА | ТЕРРА ЭНЕРЖИ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | НОЁН СУМЫН ЗАСАГ ДАРГА |
|---|---|---|
| Н.НАРАНБААТАР | О.ОЮУМАА | Б.БАТБОЛД |

# ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

№ 2017/02

| | ОРОН НУТАГ ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ | COMMUNITY DEVELOPMENT AGREEMENT |
|---|---|---|
| | Гэрээ байгуулсан огноо: 2017 оны 09-р сарын 11 | Date: 11 Set, 2017 |
| | Энэхүү гэрээг /цаашид "Гэрээ" эсхүл "ОНХГ"/<br>1. нэг талаас Өмнөговь аймаг /цаашид "Захиргаа" гэх/,<br>2. нөгөө талаас "Терра Энержи" ХХК, / цаашид "Компани" гэх/,<br>3. нөгөө талаас Ноён сум / цаашид "Орон нутгийн" гэх/, нар харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.<br><br>Тал тус бүрийг Тал, хамтад нь Талууд гэнэ.<br>Талууд энд заасан ерөнхий нөхцөлийг харилцан зөвшөөрсөн болно.<br>Энэхүү гэрээ нь Ашигт малтмалын тухай хууль болон Монгол улсын Засгийн Газрын 179 тоот шийдвэрийн дагуу Компани болон Орон нутаг хоорондын харилцааг чиглүүлэн зохицуулна.<br>Гэрээ байгуулсан талууд гэрээний хэрэгжилтэд тэгш болон төлөөллийн оролцоотойгоор хяналт тавьж ажиллана. | This agreement (the "Agreement" or "CDA") is entered into by and between:<br>1. Umnugobi aimag, hereinafter referred to as the "Administration";<br>2. Terra Energy LLC, hereinafter referred to as the "Company"; and<br>3. Noyon soum, hereinafter referred to as the "Community".<br><br>WHEREAS, each is referred to as a Party, and collectively as the Parties.<br>WHEREAS, the Parties agree on the terms and conditions set forth within.<br>WHEREAS, this Agreement governs and guides relations |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| | | between the Company and the Community in accordance with the Law on Minerals, and Resolution No.179 of 2016 of the Government of Mongolia.<br>WHEREAS, the Parties shall engage and cooperate on the implementation of the Agreement with representative participation. |
| **1.** | **НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ** | **DEFINITIONS OF TERMS** |
| 1.1 | "Төсөл" гэж Ноён сумын хэмжээнд явуулж байгаа Терра Энержи ХХК болон түүний салбар компаниудын бүх үйл ажиллагааг хэлнэ. | "Project" means all activities of Terra Energy LLC and its subsidiaries in within Noyon soum. |
| 1.2 | "Орон нутаг" гэж Ноён сумын иргэд, оршин суугчдыг хэлнэ. | "Community" means the residents of Noyon soum. |
| 1.3 | "Хамтын ажиллагааны хороо" эсхүл "ХАХ" нь 4-р заалтад заасан утгатай байна | "Community Cooperation Committee" or "CCC" has the meaning as outlined in Clause 4. |
| 1.4 | "Хамтын ажиллагааны хорооны дүрэм эсхүл "ХАХ-ны дүрэм" нь 5-р заалтад заасан утгатай байна. | "Community Cooperation Committee Charter" or "CCC Charter" has the meaning as outlined in Clause 5. |
| 1.5 | "Орон нутгийг дэмжих сан эсхүл" "ОНХС" нь 6- заалтад заасан утгатай байна." | "Community Support Fund" or "CSF" has the meaning as outlined in Clause 6. |
| **2.** | **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД** | **PRINCIPLES OF COOPERATION** |
| 2.1 | Талууд бүхий л хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд хамтран ажиллана. | The Parties shall cooperate within the framework of applicable legislation and regulation at all times. |
| 2.1 | Талууд шударгаар, харилцан бие биенийхээ ашиг сонирхлыг дэмжих, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчил болон үл ойлголцлоос ангид байх зарчмыг баримтална. | The Parties will respect the interests and works of each other Party, and communicate with one another carefully and transparently to avoid conflict and/or misunderstanding. |
| 2.3 | Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | The Parties will engage cooperatively in support of the social and economic development of the Community. |
| **3.** | **ТАЛУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ** | **RIGHTS AND OBLIGATIONS OF THE PARTIES** |
| 3.1 | Бүх Талууд: | All Parties: |
| 3.1.1 | Энэ Гэрээний Талууд хамтран ажиллах зорилготой. | To work in a spirit of cooperation with the Parties to this Agreement; |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| 3.1.2 | ХАХ-ны дүрмийн шаардлагуудад нийцүүлэн, ХАХ-ноос баталсан төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажиллана. | To support projects and programs approved by the CCC, that conform with requirements of the CCC Charter; |
| 3.1.3 | ХАХ-ны хурлуудын бүрэн тэмдэглэлүүдийг ХАХ-оос хүлээн авч, хэрэглэнэ. | To be provided with, or with access to, full minutes from all CCC meetings, by the CCC; |
| 3.1.4 | ХАХ-ны үйл ажиллагааны аливаа зөрчлөөс зайлсхийн ажиллаж байгаа нотолгоог хүсэх, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллана. | To request evidence of due diligence, or conduct audit on, the activities of the CCC; |
| 3.1.5 | ХАХ-ноос хэрэгжүүлсэн харилцан зөвшөөрсөн санаачилгуудын ахиц, биелэлтийн талаарх тайлангуудыг ХАХ-оос авах эсхүл хэрэглэх боломжтой. | To be provided with, or with access to, reports on progress and completion of agreed initiatives implemented by the CCC, by the CCC; |
| 3.1.6 | орон нутгийн ёс заншлыг хүндэтгэх, түүх, соёлын дурсгалт газрыг хадгалж, хамгаалах талаарх хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэн орон нутагтай хамтран ажиллана. | To respect local customs and traditions, and cooperate with the Community to protect historical and cultural memorials under the law; |
| 3.1.7 | Сум болон багийн хурлууд зэрэг сонгогдсон засаг захиргааны бүтцүүдийг хамруулан оролцуулах үйл явцаар дамжуулан асуудлын шийдвэрлэхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан ажиллана. | To comply with Mongolian legislation and regulations, including those related to resolution of issues through due processes involving elected administrative structures such as soum and bagh Khural meetings; |
| 3.1.8 | Улс төрийн хувьд ХАХ-г төвийг сахин ажиллуулна. | To ensure that the CCC operates with political neutrality; and |
| 3.1.9 | Гэрээг бусад, холбоогүй асуудлуудын зорилгод хүргэх хэрэгсэл бүхий механизм болгон ашиглахгүй. | To not use the Agreement as a mechanism with which to leverage other, unrelated issues. |
| 3.2 | Захиргаа | The Administration: |
| 3.2.1 | Компани болон Орон нутаг төлөвлөсний дагуу хамтран ажиллаж байгааг хангахын тулд энэ Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих | To oversee implementation of this Agreement to ensure that the Company and Community are cooperating as intended; and |
| 3.2.2 | Хуулийн дагуу олгогдсон өөрийн бүрэн эрхийн хүрээнд, Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудал эсхүл хүсэлтийг анхааран авч үзэх, шийдвэрлэх. | To consider and solve any issues or requests related to operations of the Company within its capacity granted by laws. |
| 3.3 | Орон нутаг: | The Community: |
| 3.3.1 | Монгол улсын хууль, дүрэм журмын дагуу Компанид дэмжлэг үзүүлнэ. | To provide support to the Company in accordance with Mongolian laws and regulations; |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| 3.3.2 | хуулийн хүрээнд шаардлагатай зөвшөөрөл өгөх, төслийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | To provide assistance or support to the Company to obtain any permits required by laws, and to solve any issues related to the project activities; and |
| 3.3.3 | Сум, багийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлууд дээр ХАХ-ны хурлуудын үр дүнгийн талаар ХАХ-ны гишүүд мэдээлнэ. | To be briefed regarding outcomes of the CCC meetings, at Meetings of the Citizens' Representatives of the soum and bagh, by members of the CCC. |
| 3.4 | Компани: | The Company: |
| 3.4.1 | Уурхайн төслийн хүрээнд хийгдэх бараа, бүтээгдэхүүний хангалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, зардлын хувьд зах зээлд өрсөлдөх орон нутгийн аж ахуйн нэгжээр зах зээлийн үнээр хханган нийлүүлэлтийг гүйцэтгүүлнэ. | To engage and support, where possible, local enterprises in the supply of goods and services required for the project, that are market competitive in terms of quality and cost; |
| 3.4.2 | Төслийн хүрээнд нийт ажиллагсдын 50-иас /тавь/ дээш хувийг нэн тэргүүнд Ноён сумын иргэдийг ажиллуулахыг эрмэлзэнэ. | To endeavour to employ citizens from Noyon soum as a priority, targeting minimum of fifty per cent (50%) of all employees onsite; |
| 3.4.3 | Сумын Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй орон нутгийн иргэдэд тавигдах ажлын байрны шаардлагуудыг анхааран авч үзнэ. | To consider against the agreed position requirement any local citizens for employment who are registered at the labour and care service department of Noyon soum; |
| 3.4.4 | 3.4.1, 3.4.2, 3.4.3 заалтад заасны дагуу гэрээлэгч, дэд гэрээлэгч нарыг дэмжин ажиллана. | To encourage contractors and sub-contractors similarly as per Clauses 3.4.1, 3.4.2 and 3.4.3; |
| 3.4.5 | Бүтээгдхүүн, үйлчилгээний тендер эсхүл хангамжийн талаарх аливаа хүсэлтийг ил тод, нээлттэй арга барилаар Орон нутагт мэдээлнэ. | To inform the Community of any requests for procurement or tenders for goods and services in an open and transparent manner; |
| 3.4.6 | Орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжийн оролцоо, дэмжлэг туслалцааны талаарх мэдээллийг ил тод хэвлэн нийтлэх | To transparently publish information regarding the engagement and support of local citizens and entities; |
| 3.4.7 | Хавсралт 1 [Ажлын хамрах хүрээ]-нд тодорхойлсны дагуу, төлөвлөсөн болон онцгой байдлын замын ажлуудад туслах | To assist with planned and emergency road works, as described in Appendix 1 [Scope of Works]; |
| 3.4.8 | Үндэсний хэмжээнд зарласан онцгой байдлын тохиолдолд, техник хэрэгсэл, хүн хүчний туслалцааг сайн дурын үндсэн дээр үзүүлнэ. | To provide equipment, technical assistance and workforce on voluntary basis in the event of a declared national emergency; and |
| 3.4.9 | Орон нутгийн ажилчдыг ажлын байран дээр сургаж дадлагажуулах, ажил | To train local employees at their workplaces and improve or |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| | мэргэжлийг нь дээшлүүлэх. | upgrade their professional skills. |
| **4.** | **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО** | **COMMUNITY COOPERATION COMMITTEE** |
| 4.1 | ХАХ нь зарчмын хувьд, Орон нутгаас, түүнчлэн Захиргаа болон Компаниас хүлээн авсан саналуудыг хүлээн авах, үнэлгээ хийх, хэрэгжүүлэх зорилготой. | The purpose of the CCC is to receive, evaluate and implement proposals received principally from the Community, but also from the Administration and the Company. |
| 4.2 | ХАХ гурван Зөвлөхтэй байна: | The CCC shall have three Sponsors: |
| 4.2.1 | Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч | The Deputy Governor of Umnugovi aimag; |
| 4.2.2 | Ноён сумын Засаг даргын орлогч | The Deputy Governor of Noyon soum; and |
| 4.2.3 | Компанийн гүйцэтгэх захирал | The Executive Director of the Company. |
| 4.3 | ХАХ есэн (7) гишүүнээс бүрдэнэ: | The CCC shall comprise seven (7) Members: |
| 4.3.1 | Компани гурван гишүүн томилно | Company to nominate three (3) Members; and |
| 4.3.2 | Орон нутгаас дөрвөн гишүүн томилно. | Community to elect four (4) Members. |
| 4.4 | ХАХ-ын хэмжээнд гүйцэтгэх үүрэгт дараах багтана: | Roles within the CCC shall include as follows: |
| 4.4.1 | Зөвлөхүүд ХАХ-ны өдөр тутмын үйл ажиллагааны хэсэг болж ажиллахгүй, гэхдээ ХАХ-ны гишүүдийн үйл ажиллагааг удирдан хянаж, ХАХ-ны хэмжээнд хамгийн дээд бүрэн эрхийг хамтдаа эдэлнэ. | Sponsors shall not be part of the day-to-day operation of the CCC, but shall oversee activity of Members of the CCC and collectively hold highest authority within the CCC; |
| 4.4.2 | Орон нутгийн нэг гишүүнийг ХАХ-ны даргаар томилох бөгөөд ХАХ-ны тэргүүний хувьд хорооны үйл ажиллагааг хариуцан ажиллана. | One Member from the Community shall be elected within the CCC as the Chairperson, and as the Head of the CCC shall hold responsibility for its activity; |
| 4.4.3 | Орон нутгийн нэг гишүүнийг ХАХ-ны няравын ажилд томилно. Тэр ХАХ-ны авч явуулсан үйл ажиллагааны тайлан, санхүүгийн бүртгэлийг хариуцна. | One Member from the Company shall be elected as Treasurer of the CCC, and shall be responsible for financial administration and reporting of activity undertaken by the CCC; |
| 4.4.4 | Компанийн нэг гишүүнийг ХАХ-ны нарийн бичгийн даргаар томилох бөгөөд хурлын тэмдэглэлийн бэлтгэл болон баримт бичгийн хяналт, тайлангууд, бусад харилцаа холбоог хариуцан ажиллана. | One Member from the Company shall be elected as Secretary of the CCC, and shall be responsible for preparation and document control of minutes, reports and other communication; and |
| 4.4.5 | Бусад гишүүдийн тусгай үүргийг ХАХ-ноос тогтоож болно, гэхдээ заавал тодорхойлох шаардлага тавихгүй. | Specific roles of other Members may be defined by the CCC itself, but do not require to be. |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| 4.5 | ХАХ нь Дүрэм буюу "ХАХ-ны дүрэм" боловсруулна. Энэхүү дүрэмд ХАХ-ны спонсоруудын баталсан хүрээнд бие даасан үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хяналтыг тодорхойлно. | The CCC shall develop a Charter, the "CCC Charter", which shall define controls necessary to allow for autonomous operation within a defined framework approved by the CCC sponsors. |
| **5.** | **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРООНЫ ДҮРЭМ** | **COMMUNITY COOPERATION COMMITTEE CHARTER** |
| 5.1 | ХАХ-ны дүрмийг ХАХ-ны үйл ажиллагааг чиглүүлэн зохицуулах дотоод дүрэм журмуудын цогц болгон боловсруулна. | The CCC Charter is to be developed as a set of internal bye-laws that shall govern the operation of the CCC. |
| 5.2 | ХАХ-ны дүрмийг: | The CCC Charter is to be: |
| 5.2.1 | ХАХ-ны гишүүд боловсруулна. | Developed by the CCC members; |
| 5.2.2 | ХАХ-ны спонсорууд батална. | Approved by the CCC sponsors; and |
| 5.2.3 | Нэмэлт өөрчлөлтөөр, энэ гэрээний хэсгийг бүрдүүлэх бөгөөд заавал биелүүлэх үүрэг байна. | Form part of this Agreement, by amendment, and thus binding. |
| 5.3 | ХАХ-ны дүрмийн нөхцөлүүдэд дараах хэсгүүдийн талаар дэлгэрэнгүй багтаан оруулсан байна, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй: | Provisions shall be made within the CCC Charter to adequately cover in appropriate detail aspects including but not limited to: |
| 5.3.1 | аж ахуйн нэгж үүсгэн байгуулах | Entity establishment; |
| 5.3.2 | бүрэн эрхүүдийг тодорхойлох | Definition of authorities; |
| 5.3.3 | ХАХ-ны төсөв, үүнд үйл ажиллагааны зардал багтана | CCC budget including operating costs; |
| 5.3.4 | Нягтлан бодох бүртгэл болон аудитын шаардлагууд | Accounting and audit requirements; |
| 5.3.5 | Саналын үнэлгээний аргачлал | Proposal evaluation methodology; |
| 5.3.6 | Хангамжийн үйл явцууд | Procurement processes; and |
| 5.3.7 | Тайлагнах, харилцан мэдээлэх шаардлагууд | Reporting and communication requirements. |
| **6.** | **ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ САН** | **COMMUNITY SUPPORT FUND** |
| 6.1 | Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудлыг хэрэгжүүлэхэд харилцан зөвшөөрсөн, үнэлгээ өгсөн саналуудыг ХАХ-ны хувьд батлан хэрэгжүүлэхийн тулд, Компани Орон нутгийг дэмжих санд (ОНДС)-нд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | In order for the CCC to enact proposals for local social and economic development evaluated and agreed to be implemented for the Community, the Company shall make financial contributions to a Community Support Fund ("CSF"). |
| 6.2 | ОНХС-нд оруулах Компанийн тусламжийн хэмжээ сар тутамд хорин | The Company contribution to the CSF will be twenty-five million |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| | таван сая төгрөг (25 000 000) байх бөгөөд сарын эцэст 30 хоногийн дотор төлөх ёстой. | Mongolian tugrug per month (MNT 25,000,000 p.m.), payable within 30 days of the end of the month. |
| 6.3 | Компанийн хандив тусламжийн мөнгийг ХАХ-ны дүрэмд тодорхойлсон дансанд байршуулна. | The Company contributions will be deposited into an account as defined within the CCC Charter. |
| 6.4 | Дараах тохиолдолд Компани нь ОНДС-д төлөх сарын төлбөрөөс чөлөөлөгдөнө: | The Company is excepted from making monthly contribution to the CDF in any month if: |
| 6.4.1 | Тухайн сард аливаа шалтгаанаар нүүрс экспортлоогүй бол, Монгол улсын гаалийн байгууллагаас баримтжуулсан байх, | For any reason, where no coal has been exported in such month, as documented by the Mongolian Customs Authority; |
| 6.4.2 | Орон нутгийн иргэдийн хууль бус үйл ажиллагааны улмаас нүүрсний экспорт ноцтойгоор тасалдсан бол, сарын хугацаанд (ажил) тасалдсан өдрийн тоотой пропорционалиар уялдуулан төлбөл зохих төлбөрийн дүнг хоног тутам бууруулна. | Where coal export is seriously disrupted by illegal activities of the Community, amount payable shall be reduced on daily pro rata basis relative to the number of days disruption in month; or |
| 6.4.3 | Орон нутгийн иргэдийн хууль бус үйлдлийн улмаас Компанийн үйл ажиллагаа (жишээ нь, олборлолт, хайгуул эсхүл аливаа бусад ердийн бизнесийн үйл ажиллагаа) экспорт ноцтойгоор тасалдсан бол, сарын хугацаанд (ажил) тасалдсан өдрийн тоотой пропорционалиар уялдуулан төлбөл зохих төлбөрийн дүнг хоног тутам бууруулна. | Where Company operation (e.g. mining, exploration or any other usual business activity) is seriously disrupted by illegal activities of the Community, amount payable shall be reduced on daily pro rata basis relative to the number of days disruption in month. |
| 6.5 | Энэхүү Гэрээг Хүчин төгөлдөр болсон өдөр хүчинтэйд тооцох бөгөөд Орон нутгийн хэмжээнд Компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байх хугацаанд хүчинтэй хэвээр байна. /2017 оны 06 сарын 01/ | This agreement shall be in force from the Effective Date, and shall remain in force whilst soever the Company continues to conduct business activities within the Community. /01 June, 2017/ |
| **7.** | **МАРГААН ШИЙДВЭРЛЭХ** | **CONTRACT LAW AND DISPUTE SETTLEMENT** |
| 7.1 | Энэ Гэрээг Монгол улсын хуулиар зохицуулна. | Agreement entered into between the Parties shall be governed by and construed in accordance with the Laws of Mongolia. |
| 7.2 | Энэ Гэрээтэй холбогдуулан эсхүл түүний хэрэгжилтийн явцад гарсан аливаа маргааныг Талууд ийнхүү нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш гуч (30) хоногийн дотор харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ. | The Parties shall attempt to amicably resolve by mutual consultation disputes arising between them in connection with or as a result of this Agreement within thirty (30) days of either Party's notice of the dispute to the other. |
| | Маргааныг Гэрээний 7.2- заалтад заасны дагуу харилцан тохиролцох замаар шийдээгүй нөхцөлд талууд Монгол улсын шүүхээр эцэслэн шийдүүлнэ.э | Should efforts to resolve disputes under the Clause 7.2 fail, the Parties shall resolve the dispute at the Court of Mongolia. |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**
**THE AGREEMENT IS MADE BY:**

| | | |
|---|---|---|
| Аймгийн төлөөлж:<br>On behalf of the Administration: | С. Мөнхбаяр<br>Munkhbayar S. | Өмнөговь аймгийн засаг даргын орлогч<br>Deputy Governor of Umnugobi aimag |
| Орон нутгийг төлөөлж:<br>On behalf of the Community: | Д. Анхбаяр<br>Ankhbayar D. | Ноён сумын засаг даргын орлогч<br>Deputy Governor of Noyon soum |
| Компанийг төлөөлж:<br>On behalf of the Company: | Д.Нэмэхбат<br>Nemekhbat.D | Уурхайн дарга, “Терра Энержи” ХХК<br>Site manager “Terra Energy” LLC |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| | **ХАВСРАЛТ 1:**<br>**НОЁН СУМЫН ЗАМЫН ТЕХНИК ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ** | **ATTACHMENT 1:**<br>**SCOPE OF WORK FOR NOYUN SOUM ROAD MAINTENANCE** |
| **1.** | **Ажлын хамрах хүрээ** | **Scope of Work** |
| 1.1 | Дараах үйлчилгээг Ноён суманд үзүүлнэ. Үүнд:<br>4. Төслийн талбайгаас Ноён сум хүртэлх замыг улирал тутам тэгшлэх (ойролцоогоор 20 км)<br>5. Наадмын морины уралдааны замыг жил бүр тэгшлэх (ойролцоогоор 10 км)<br>6. Цаг агаарын онцгой нөхцөл байдлаас шалтгаалан (зам нурах эвдрэх), хүсэлтийн дагуу Төслийн талбайгаас Ноён сум хүртэлх замд засвар үйлчилгээ хийх | The following services are to be provided to Noyon soum:<br>7. Grading of the road from the Project to Noyon soum on a quarterly basis (approximately 20 kilometres);<br>8. Grading of the Nadaam horse racing circuit on an annual basis (approximately 10 kilometres); and<br>9. Emergency repairs where required as result of extreme weather conditions (i.e. wash outs) to the road from the Project to Noyon, upon request and acknowledgement that repairs requested are not for routine maintenance. |
| **2.** | **Компанийн эрх, үүрэг** | **Rights and Obligations of the Company** |
| 2.1 | Ажлыг гүйцэтгэхэд зориулан грэйдэрээр хангах, үүнд түлш багтана. | Provision of a grader to implement the Scope of Works, inclusive of fuel. |
| 2.2 | Ажлыг гүйцэтгэхийн тулд ажилтнууд болон хяналт удирдлагаар хангах, XXXX-аар хангах | Provision of personnel including supervision, complete with required PPE, to implement the Scope of Works |
| 2.3 | 1.1 a) болон 1.1 b) зүйлийн цаг хугацааг баталгаажуулах үүднээс хамгийн багадаа хоёр долоо хоногийн өмнө Орон нутагт (Ноён сумын захиргаагаар дамжуулан) харилцан мэдээлэх | Communication confirming timing of items 1.1 a) and 1.1 b) with the Community (via Noyon soum administration) a minimum of two (2) weeks in advance. |
| 2.4 | Тоног төхөөрөмж, операторуудын бүх зөвшөөрөл, гэрчилгээ, лиценз, даатгалууд | All permits, certificates, licenses and insurances for equipment and operators. |
| 2.5 | Шаардлагатай тохиолдолд, яаралтай мэдэгдэл авсан даруйд Компанийн үйл ажиллагааны шаардлагын дагуу тоног төхөөрөмж, ажиллах хүчийг эрэмбийн дагуу тараан байрлуулах чадвар | Ability to prioritize deployment of equipment and personnel to address Company operational requirements at short notice, if required. |
| **3.** | **Орон нутгийн эрх, үүрэг** | **Rights and Obligations of the Community** |
| 3.1 | Харилцан зөвшөөрсөн төлөвлөгөөг ЦӨ-д бэлтгэн өгөх, үүнд дараах багтана: | Provision of an agreed plan to TU including:<br>12. Agreed areas for soum road maintenance works. |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | |
|---|---|---|
| | 10. Сумын замын техник засвар үйлчилгээний ажилд зориулан харилцан зөвшөөрсөн талбай<br>11. Сумын замын техник засвар үйлчилгээний ажилтай холбоотой харилцан зөвшөөрсөн огноо | 13. Agreed dates for soum road maintenance works. |
| 3.2 | Компанийн болон орон нутгийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангахын тулд харилцан тохиролцсон техник засвар үйлчилгээний ажлын явцад орон нутгийн замын хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх үүднээс цагдаагийн хамгаалалт гаргах, бусад дэмжлэг үзүүлэх | Provision of police escort and/or other support to manage community road traffic during the agreed maintenance works to ensure safety of Company and Community personnel. |
| 3.3 | Аюулгүй байдлыг хангах, ойлгуулах үүднээс, хийхээр төлөвлөж буй техник засвар үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг орон нутагт мэдээлэх | Communication to the community regarding details of upcoming maintenance works, to ensure awareness and enhance safety. |
| 3.4 | Зам засварын ажил бүр дээр тусламж дэмжлэг үзүүлснийг хүлээн зөвшөөрч ойлгон, Компанийн боловсруулсан тайланд гарын үсэг зурах. Энэ нь аюулгүй байдал болон орон нутгийн үйл ажиллагааны талаарх компанийн тайлан юм. | To sign a report drafted by the Company, acknowledging the support given following each maintenance event. This is for corporate reporting of safety and community activities. |
| 3.5 | Замын ажил, үйлчилгээний бүх зөвшөөрөл, гэрчилгээ, лиценз, даатгалууд | All permits, certificates, licenses and insurances for road works and services. |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN